



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 5/29

Бор-өндөр сум

**Ээлжийн амралт олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1.5, 99 дүгээр зүйлийн 99.1, 99.3, 99.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Рентген техникч Ж.Солонго, Нягтлан бодогч Т.Эрдэнэболор нарын 2023 оны ээлжийн амралтыг олгож, амралтын хоног хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Ж.Солонго, Т.Эрдэнэболор нарт ээлжийн амралтын олговрыг зохих журмын дагуу тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Б.Энхмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР

